

АРХАНГАЙ АЙМГИЙН
УС, ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ

МЭРГЭЖИЛ ТАНИУЛАХ, СУРТАЛЧИЛАХ ЧИГЛЭЛЭЭР
ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН МЭДЭЭ

2025 оны 05 дугаар сарын 16

Эрдэнэбулган сум

Монгол Улсын Их Сургуулиас бэлтгэсэн брошур танилцуулга болон байгууллага зохион байгуулсан сургалт мэдээллийг дунд сургуулийн сурагчдыг ажил үйлчилгээ, мэргэжилтэйгээ танилцуулсан талаар дараах ажлыг зохион байгууллаа.

1. Тариат, Эрдэнэмандал, Төвшрүүлэх, Батцэнгэл, Хайрхан сумдын цаг уурын өртөө, харуулын хамт олон сумын ЕБС-ийн 11, 12 дугаар ангийн сурагчдад мэргэжлээ танилцуулах ажлыг зохион байгуулж, сургалт өгч, шинжилгээ судалгаанд ашиглагдаж байгаа багаж, тоног төхөөрөмжийн ажиллагааг танилцууллаа.
2. Цахир сумын АБТА Г.Болд багшийн нэрэмжит 1-5 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгуулагдсан монгол хэл, математикийн олимпиадын үеэр сургуулийн удирдлага болон холбогдох багш нарт мэргэжлийн онцлог байдлыг танилцуулж, брошур танилцуулга зэргийг хүлээлгэж өглөө.











